



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын ерөнхий боловсролын Гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/25/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:Ankhbayard@audit.gov.mn">Ankhbayard@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn">Enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: П.Содном Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:Sodnomp@audit.gov.mn">Sodnomp@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал .....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт .....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 55  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН СУМЫН ГУРАВДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.ГЭРЭЛТУЯА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын гуравдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын гуравдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020058

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>60,306,422.09</b>	<b>76,876,097.09</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	20,939,800.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	20,939,800.00
3351	Байгууллагаас авах авлага	-	20,939,800.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	60,306,422.09	55,936,297.09
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,949,700.00	49,970.00
35110	Тусгай зориулалттай материал	1,949,700.00	49,970.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	58,356,722.09	55,886,327.09
35410	Бичиг хэргийн материал	686,200.00	1,341,200.00
35420	Аж ахуйн материал	46,584,102.09	44,382,502.09
35440	Түлш, шатах тослох материал	1,904,360.00	1,139,360.00
35460	Хүнсний материал	2,283,160.00	2,736,265.00
35470	Бусад хангамжийн материал	6,898,900.00	6,287,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,314,511,216.58</b>	<b>4,236,917,339.59</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,314,511,216.58	4,236,917,339.59
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,190,177,883.13	4,112,888,506.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,186,400,000.00	4,186,400,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(197,691,110.96)	(250,021,110.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	145,544,602.02	147,208,602.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(41,561,933.13)	(63,300,123.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	112,558,097.00	115,008,096.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,486,749.42)	(35,510,447.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,565,760.00	10,565,760.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,113,152.00)	(3,698,016.00)
39217	Ном	2,962,369.62	6,235,746.23
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	124,333,333.45	124,028,833.48
39301	Програм хангамж	2,030,000.00	2,030,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(396,666.55)	(701,166.52)
39303	Бусад биет бус хөрөнгө	122,700,000.00	122,700,000.00

3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,374,817,638.67</b>	<b>4,313,793,436.68</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,374,817,638.67</b>	<b>4,313,793,436.68</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	4,374,817,638.67	4,313,793,436.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	122,700,000.00	122,700,000.00
51101	Өмч: - төрийн	122,700,000.00	122,700,000.00
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	4,252,117,638.67	4,191,093,436.68
51210	Өмнөх үеийн үр дүн	4,252,117,638.67	4,252,117,638.67
51220	Тайлант үеийн үр дүн	-	(61,024,201.99)
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,374,817,638.67</b>	<b>4,313,793,436.68</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>971,712,766.73</b>	<b>946,793,382.61</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>48,674,166.73</b>	<b>3,139,175.61</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	48,674,166.73	3,139,175.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,674,166.73	3,139,175.61
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	48,674,166.73	3,139,175.61
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>923,038,600.00</b>	<b>943,654,207.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	746,042,200.00	751,704,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	746,042,200.00	751,704,100.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,235,000.00	816,707.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,235,000.00	816,707.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	170,761,400.00	191,133,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	170,761,400.00	191,133,400.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>967,809,418.25</b>	<b>1,007,817,584.60</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>967,809,418.25</b>	<b>1,007,817,584.60</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	944,188,848.45	987,160,143.43
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	583,251,778.21	599,727,750.83
210101	Үндсэн цалин	398,547,659.34	470,742,999.01
210102	Нэмэгдэл	101,123,918.87	80,275,349.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,000,000.00	19,353,962.00
210104	Урамшуулал	58,580,200.00	29,355,440.38
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	78,189,837.39	76,321,000.00

210201	Тэтгэврийн даатгал	54,714,000.00	52,294,910.49
210202	Тэтгэмжийн даатгал	5,901,400.00	6,006,522.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,721,200.00	4,805,217.90
210204	Ажилгүйдлийн даатгал	1,180,300.00	1,201,304.47
210205	Эрүүл мэндийн даатгал	11,672,937.39	12,013,044.77
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>168,830,458.00</b>	<b>189,633,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	9,156,882.00	11,192,968.51
210302	Түлш, халаалт	152,743,900.00	177,624,431.49
210303	Цэвэр, бохир ус	6,929,676.00	816,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,839,418.00</b>	<b>12,337,100.00</b>
210401	Бичиг хэрэг	2,410,700.00	650,500.00
210402	Тээвэр, шатахуун	808,140.00	765,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,713,838.00	1,544,840.00
210404	Ном, хэвлэл	79,300.00	18,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,861,100.00	1,891,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,524,840.00	7,467,160.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,441,500.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>11,220,271.00</b>	<b>19,025,640.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	193,000.00	183,700.00
210502	Хоол, хүнс	11,027,271.00	18,689,060.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	152,880.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>441,309.00</b>	<b>1,483,000.00</b>
210604	Урсгал засвар	441,309.00	1,483,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>80,000.00</b>	<b>123,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	80,000.00	123,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,540,000.00</b>	<b>100,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,216,000.00	100,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>85,795,776.85</b>	<b>88,408,752.60</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	951,750.00	1,703,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,772,850.00	1,724,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,071,176.85	84,981,252.60
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>23,620,569.80</b>	<b>20,657,441.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,827,115.00</b>	<b>17,366,590.00</b>

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,750,315.00	16,316,590.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,076,800.00	1,050,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>14,793,454.80</b>	<b>3,290,851.17</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,793,454.80	3,290,851.17
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>3,903,348.48</b>	<b>(61,024,201.99)</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>3,903,348.48</b>	<b>(61,024,201.99)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,700,000.00	-	4,248,214,290.19	4,370,914,290.19
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,700,000.00	-	4,248,214,290.19	4,370,914,290.19
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	3,903,348.48	3,903,348.48
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,700,000.00	-	4,252,117,638.67	4,374,817,638.67
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	122,700,000.00	-	4,252,117,638.67	4,374,817,638.67
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	122,700,000.00	-	4,252,117,638.67	4,374,817,638.67
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(61,024,201.99)	(61,024,201.99)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	122,700,000.00	-	4,191,093,436.68	4,313,793,436.68

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>930,263,392.00</b>	<b>943,654,207.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,224,792.00</b>	-
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,224,792.00	-
120009	Бусад орлого	7,224,792.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>923,038,600.00</b>	<b>943,654,207.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	746,042,200.00	751,704,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	746,042,200.00	751,704,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,235,000.00	816,707.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,235,000.00	816,707.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	170,761,400.00	191,133,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	170,761,400.00	191,133,400.00

<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>910,499,342.00</b>	<b>940,371,307.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>910,499,342.00</b>	<b>940,371,307.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>884,313,659.60</b>	<b>921,779,065.83</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	584,166,436.21	595,727,750.83
210101	Үндсэн цалин	399,683,410.34	373,691,467.30
210102	Нэмэгдэл	100,902,825.87	151,134,142.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,000,000.00	28,911,462.00
210104	Урамшуулал	58,580,200.00	41,990,679.38
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	78,189,837.39	80,321,000.00
210201	Тэтгэврийн даатгал	54,714,000.00	56,385,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,901,400.00	5,891,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,721,200.00	4,879,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,180,300.00	1,196,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,672,937.39	11,967,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	168,830,458.00	189,633,400.00
210301	Гэрэл, цахилгаан	9,156,882.00	11,192,968.51
210302	Түлш, халаалт	152,743,900.00	166,793,450.00
210303	Цэвэр, бохир ус	6,929,676.00	11,646,981.49
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,316,188.00	8,325,407.00
210401	Бичиг хэрэг	363,400.00	720,107.00
210402	Тээвэр, шатахуун	1,812,500.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,713,838.00	1,544,840.00
210404	Ном, хэвлэл	79,300.00	18,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,773,000.00	3,495,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,574,150.00	2,546,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	18,961,226.00	19,724,315.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	168,000.00	183,800.00
210502	Хоол, хүнс	17,659,226.00	19,307,635.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,134,000.00	232,880.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,528,000.00	14,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	13,000,000.00
210604	Урсгал засвар	1,528,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	80,000.00	123,500.00
210702	Дотоод албан томилолт	80,000.00	123,500.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,182,200.00	155,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,858,200.00	155,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	9,059,314.00	13,268,693.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,898,464.00	1,818,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,160,850.00	11,450,493.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>26,185,682.40</b>	<b>18,592,241.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	11,392,227.60	15,301,390.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,292,427.60	14,251,390.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,099,800.00	1,050,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	14,793,454.80	3,290,851.17
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,793,454.80	3,290,851.17
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>19,764,050.00</b>	<b>3,282,900.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>19,764,050.00</b>	<b>3,282,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>19,764,050.00</b>	<b>3,282,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	19,764,050.00	3,282,900.00
222001	Тоног төхөөрөмж	19,764,050.00	3,282,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(19,764,050.00)</b>	<b>(3,282,900.00)</b>
250005	Төлсөн ногдол ашиг		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	942837500.00	939546648.83
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	942837500.00	939546648.83
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	927457000.00	924245258.83
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	598346000.00	595727750.83
210101	Үндсэн цалин	379205400.00	373691467.30
210102	Нэмэгдэл	155123800.00	151134142.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22000000.00	28911462.00
210104	Урамшуулал	42016800.00	41990679.38
210105	Гэрээт ажлын хөлс		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	80321000.00	80321000.00

210201	Тэтгэврийн даатгал	56385900.00	56385900.00
210202	Тэтгэмжийн даатгал	5891700.00	5891700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4879100.00	4879100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1196700.00	1196700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11967600.00	11967600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	189633400.00	189633400.00
210301	Гэрэл, цахилгаан	13236000.00	11192968.51
210302	Түлш, халаалт	163113200.00	166793450.00
210303	Цэвэр, бохир ус	13284200.00	11646981.49
210304	Байрны түрээс		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9040100.00	8991600.00
210401	Бичиг хэрэг		283400.00
210402	Тээвэр, шатахуун		0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,700,000.00	1,544,840.00
210404	Ном, хэвлэл	211,800.00	146,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,305,900.00	3,115,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,822,400.00	3,900,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,816,300.00	19,724,315.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	275,700.00	183,800.00
210502	Хоол, хүнс	19,307,700.00	19,307,635.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	232,900.00	232,880.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	14,500,000.00	14,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	13,000,000.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	264,700.00	123,500.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	264,700.00	123,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	160,000.00	155,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,000.00	155,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,375,500.00	15,068,693.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,125,000.00	1,818,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,250,500.00	13,250,493.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	15,380,500.00	15,301,390.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	15,380,500.00	15,301,390.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,330,500.00	14,251,390.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,050,000.00	1,050,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	942,837,500.00	942,837,500.00

<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	751,704,100.00	751,704,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	751,704,100.00	751,704,100.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	191,133,400.00	191,133,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	191,133,400.00	191,133,400.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	51.00	51.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	37.00	37.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00
620004	Гэрээт ажилтан		
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	388.00	388.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	388.00	388.00
630001	Төрийн өмчит ЕБС	388.00	388.00
630002	Хувийн ЕБС		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>816,707.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>816,707.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	816,707.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	816,707.00
210401	Бичиг хэрэг		436,707.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		380,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	816,707.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	816,707.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	816,707.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын Гуравдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдлийг хангах, авлага, өглөг үүсгэхгүй байхгүй, анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор П.Содном гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын ерөнхий боловсролын Гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Булган сумын ерөнхий боловсролын Гуравдугаар сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилд 49 орон тоотойгоор сургалт хүмүүжлийн болон бусад үйл ажиллагаагаа явууллаа. Үүнээс захирал 1, сургалтын менежер 2, нийгмийн ажилтан 1, багш 25, ажилчин 18. Багш, ажилчдын 69 хувь эмэгтэй, 31 хувь нь эрэгтэй ажилчин эзэлж байна.

Удирдах ажилтан, багш нарын 62 хувь мэргэжлийн зэрэгтэй бөгөөд үүнээс Зөвлөх зэрэгтэй 1, Тэргүүлэх 11, Заах аргач зэрэгтэй 6 багш байна.

Энэ хичээлийн жилд бага ангийн, байгалийн ухааны, хэл шинжлэл нийгмийн ухааны, математик мэдээлэл зүй физик технологийн гэсэн 4 заах аргын нэгдэл, захиргаа, аж ахуй, дотуур байр, гэсэн бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр 423 суралцагчдад боловсролын үйлчилгээг тасралтгүй хүргэн ажиллаж байна. Нийт суралцагчдын 54 хувь эмэгтэй 46 хувь нь эрэгтэй суралцагч суралцаж байна. Сургуулийн дотуур байранд нийт суралцагчдын 32 хувь нь хамрагдаж байгаа бөгөөд бага ангиас 5, дунд ангиас 7, ахлах ангиас 29 суралцагч байна.

Энэ хичээлийн жилд “Суралцагчдын суралцах идэвхтэй үйлийг дэмжсэн хичээлийг үр дүнтэй зохион байгуулж, суурь чадамж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн зөв дадал, чадварыг төлөвшүүлэхэд бүх талын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлнэ.” гэсэн зорилгыг тавин ажиллажээ.

Дараах зорилтыг дэвшүүлжээ.

- Суурь чадамжийг баттай эзэмшүүлэх
- Танхимын ба танхимын бус сургалтыг зохион байгуулах бэлтгэл арга зүйг хөгжүүлэх
- Багшийн арга зүйг дэмжин түгээн дэлгэрүүлэх
- Суралцагчдын хэрэгцээ сонирхолд нийцсэн хөгжүүлэх сургалтыг чанартай зохион байгуулах, үр дүнг тооцох.
- “Би Монгол хүн хөтөлбөр” хөгжүүлэх
- Эрүүл хүүхэд-аюулгүй орчин-эко сургууль хөтөлбөр хэрэгжүүлэх.
- Багш, эцэг, эх олон нийтийн хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт нөлөөгүй байна. Дотоод хяналтын жилийн төлөвлөгөөнд 9 хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 3 хяналт шалгалтыг зохион байгуулсан төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй

байгаа нь байгууллагын дотоод хяналт шалгалтын журмын 2.3, бусад холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Булган сумын ерөнхий боловсролын Гуравдугаар сургуулийн бүтэц орон тоонд дотоод аудит байхгүй бөгөөд дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс 2021 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын ерөнхий боловсролын Гуравдугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн нийт зардлын 524.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын ерөнхий боловсролын Гуравдугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62.4 сая төгрөгөөр өссөн нь авлага, үндсэн хөрөнгө, бараа материал өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мян.төг /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	0	20939.8	20,939.80
Бараа материал	60306.4	55936.3	-4,370.10
Үндсэн хөрөнгө	4,314,511.20	4,236,917.30	-77,593.90
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,374,817.60</b>	<b>4,313,793.40</b>	<b>-61,024.20</b>
<b>Өглөг</b>			<b>0.00</b>

Хуримтлагдсан үр дүн	4,252,117.60	4,191,093.40	-61,024.20
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>4,374,817.60</b>	<b>4,313,793.40</b>	<b>-61,024.20</b>

**Авлага:** Тайлант онд шинээр 20.9 сая төгрөгийн авлага үүссэн нь оны эцэст төсөвт зохицуулалт хийснээр цахим самбар, математик танхим тохижуулах хөрөнгө худалдан авах гэрээг хийж 2022 оны 01 дүгээр сарын 31-нд бараа нийлүүлэхээр гэрээнд тусгаж санхүүжилтийг олгосноор авлага үүссэн байна.

**Бараа материал:** Бараа материалын оны эхний үлдэгдэл 60.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 55.9 сая төгрөг болж өмнөх оноос 4.3 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 52.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 51.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 0.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж орлогоор тусгасан байна.

Нийт 56.7 мянган төгрөгийн бараа материал хасагдсанаас 55.3 сая төгрөг зарцуулж, үндсэн хөрөнгийн дансанд 1.4 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлсэн байна.

**Үндсэн хөрөнгө:** Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4582.8 сая, эцсийн үлдэгдэл 4590.1 сая төгрөг болж өмнөх оноос 7.3 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 3.3, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 2.7 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, бараа материалын данснаас 1.4 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан, акталж данс бүртгэлээс хассан хөрөнгө байхгүй байна.

**Өр төлбөр:** Өр төлбөр данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 5 арга хэмжээнд зориулан 942.8 сая төгрөгийн төсөв баталснаас 751.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 191.1 төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 751.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 191.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, 939.5 сая төгрөгийг зарцуулж 3.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 939.5 сая төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь цалин түүнтэй адилтгах зардал 2.6, бараа үйлчилгээний зардал 0.3 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Боловсролын үнэлгээний төвөөс сурагчдаас хоцрогдлын үнэлгээний шалгалтанд бичиг хэргийн зардалд зориулж 0.2, БСГ-аас ариутгал халдвар хамгаалал 0.4, сурагчдаас хоцрогдлын үнэлгээний шалгалтанд бичиг хэргийн зардалд зориулж 0.3 нийт 0.8 сая төгрөгийн санхүүжилт авч бичиг хэргийн зардалд 0.4, ариутгалд 0.4 сая сая төгрөгийн зарцуулах эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллага 2021 оны батлагдсан төсөвт зардлын 0.3 хувиар буюу 3.3 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан,
- Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний батлагдсан төсөвт хэмнэлт гараагүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлан үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээлэл байршуулахаас батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд 20939800 төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", ЗГ-ын 2021 оны 43 тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна.

Дотоод хяналтын жилийн төлөвлөгөөнд 9 хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 3 хяналт шалгалтыг зохион байгуулсан төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байгаа нь байгууллагын дотоод хяналт шалгалтын журмын 2.3, бусад холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар нийт 14094.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5378.0 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 4405.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 4310.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч хэрэгжилтийг бүрэн хангасан байна.

### **3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 22.2 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 1.3 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 0.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 20.9 сая төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өгч, 0.2 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн байна.

### **4.1 Залруулсан алдаа**

Тайлант онд үнэ төлбөргүй ирсэн 1328476.61 төгрөгийн ном орлогод аваагүй, санхүүгийн тайланд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалтыг зөрчсөн байна.

НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна. гэсэн заалтын дагуу залруулга хийсэн.

### **4.2 Төлбөрийн акт**

Бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас Булган сумын ЗДТГ-ын засварт 100000 төгрөгийг урсгал засварын материалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-д "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

### **4.3 Албан шаардлага**

Тайлант онд 20939800 төгрөгийн хөрөнгө бэлтгэхээр гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгож авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", ЗГ-ын 2021 оны 43 тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Албан шаардлага өгсөн.

### **4.4 Зөвлөмж**

**Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:**

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан шатахууны зардлаас 210200 төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг хэрэгжүүлэх.

#### **2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой**

3.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд 146 мэдээлэл байршуулахаас батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Мэдээллийн ил тод байдлыг ханган, тогтоосон хугацаанд тогтмол мэдээлж, хууль, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

### **3. Дотоод хяналттай холбоотой**

3.1 Илрүүлэлт: Дотоод хяналтын жилийн төлөвлөгөөнд 9 хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 3 хяналт шалгалтыг зохион байгуулсан төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байгаа нь байгууллагын дотоод хяналт шалгалтын журмын 2.3, бусад холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.2 Өгсөн зөвлөмж: Дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
			Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	6	22.2	1	1.3	1	0.1	1	20.9	3	0.2
Дүн										